



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 01

Улсынбодлогч хэл

"Хилийн зарим боомтыг
тур хаасантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай"

Шинэ коронавирусийн халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн "Хилийн зарим боомтыг тур хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 39 дүгээр тогтоолыг үндэслэн Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хуралдаанаар үүрэг болгосны дагуу Улсын онцгой комиссын шийдвэрийг үндэслэж БНХАУ руу албан ажлын зайлшгүй шаардлагаар холбогдох албан тушаалтан, ажилтанг улсын хилээр нэвтрүүлнэ. "Албан ажлын зайлшгүй шаардлага" гэдэгт төрийн байгууллагын ажлын шугамаар БНХАУ дахь хөл хорио тогтоогоогүй бүс нутагт гэрээ, хэлэлцээр хийх, албаны уулзалт зохион байгуулах зэрэг урьдчилж төлөвлөсөн ажлыг хамааруулж ойлгоно.

2. Гадаад улсад урт хугацаагаар амьдрах эрхтэй байнгын оршин суудаг, ажиллаж, суралцдаг бөгөөд Монгол Улсад тур зорчин ирээд байгаа болон хүндэтгэн үзэх шалтгаантай, дараах шаардлага хангасан иргэдийг улсын хилээр нэвтрүүлэхийг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн наарт үүрэг болгосугай. Үүнд:

2.1. БНХАУ-д байнгын оршин суудаг, ажил хөдөлмер эрхэлдэг, суралцдаг Монгол Улсын иргэдийг Засгийн газрын тогтоолын дагуу хилийн боомтын нэвтрэх хөдөлгөөнийг хэвийн болтол эргэж ирэхгүй тохиолдолд баталгаа гаргуулж тухайн иргэнийг 1 удаа агаарын болон төмөр замаар улсын хил нэвтрүүлэх (гаргах);

2.2. БНХАУ-аар дамжин өнгөрч гуравдагч орон луу зорчилоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоол гарахаас өмнө урьдчилж тасалбар захиалсан гадаадад сурч, ажил хөдөлмөр эрхэлдэг Монгол Улсын иргэдийг 1 удаа агаарын болон төмөр замаар баталгаа гаргуулж улсын хилээр нэвтрүүлэх (гаргах);

Тайлбар: Тогтоолын 2.2-т заасан иргэд БНХАУ-аар дамжихдаа зөвхөн нисэх буудлын транзит замаар дамжин өнгөрнө.

2.3. БНХАУ-ын иргэнтэй гэр бүл болсон, 0-18 насны хүүхэдтэй Монгол Улсын иргэний (эхнэр, нөхөр, хүүхэд нь хятад улсын иргэн) БНХАУ-ын Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны харьяа Иргэний хэргийн газраас эхнэр, нөхрийг нь баталж нотолгоо гаргасан тохиолдолд улсын хилээр 1 удаа нэвтрүүлэх;

2.4. БНХАУ-д хот хоорондын хеделгэвенийг түр зогсоож, хөл хороо тогтоосны улмаас Монгол Улсын Засгийн газрын 39 дүгээр тогтоолын 1.2-т дурдагдсан боомтуудад очих боломжгүй Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод авто замын боомтуудад байгаа Монгол Улсын иргэдийг улсын хилээр 1 удаа нэвтрүүлэх;

2.5. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, тэдгээрийн дундаас төрсөн 0-18 нас хүртэлх хүүхдийг улсын хилээр 1 удаа нэвтрүүлэх;

2.6. БНХАУ дахь хөл хороо тогтоогоогүй бүс нутагт тогтмол эмчилгээ хийлгэдэг, эмнэлгийн хяналтад байдаг, эмнэлгийн төлөвлөгөөт болон яаралтай хагалгаанд орох Монгол Улсын иргэдийн хүсэлтийг тухайн эмнэлгийн байгууллага нотломж гаргаж баталгаажуулсан тохиолдолд холбогдох баримт бичгийг үндэслэж агаарын болон төмөр замаар улсын хилээр нэвтрүүлэхийг тус тус зөвшөөрсүгэй.

2.7. Энэ тогтоолын 1, 2 дахь зүйлд заасан иргэдийг БНХАУ руу улсын хилээр нэвтрүүлэхдээ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн

байгууллагуудын тавьсан шаардлагыг биелүүлж, холбогдох дүрэм, журмыг чанд мөрдеж, Монгол Улсад буцаж ирэхтэй холбоотой зардал, төлбөрийг өөрсдөө хариуцах баталгааг гаргуулж нэвтрүүлэхийг үүрэг болгосугай.


3. Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоол гарахаас өмнө болон энэ тогтоолын 1, 2 дахь зүйлд заснаас бусад тохиолдолд авто зам, төмөр зам, агаарын хөлгөөр БНХАУ руу зорчихоор урьдчилан тасалбар авсан иргэдийн тасалбарын үнийг эргүүлэн олгож, тус улс руу зорчих тасалбар түгээх үйл ажиллагааг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоож, хяналт, шалгалтыг сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Улсын онцгой комисст өдер бүр танилцуулж, тайланг iok@nema.gov.mn, sanjaa@cabinet.gov.mn хаягаар тогтмол ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Хил хамгаалах еренхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолыг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрденө.

ОРЛОГЧ ДАРГА,

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



Н.ЭНХБОЛД